

МОНОС ХҮНС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 10 өдөр

№ 03/05

Улаанбаатар хот

Зээл авах, гэрээнд гарын үсэг
зурах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.6 дахь хэсэг, “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

- “Монос хүнс” ХК-ийн үйлдвэрийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зориулан Худалдаа хөгжлийн банкнаас Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй “Хүнсний болон хөдөө аж ахуйг дэмжих зээл” хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэртэй, жилийн 5% хүйтэй, 24 сарын хугацаатай 3 000 000 000 /турван тэрбум/ төгрөгийн зээлийг авахыг зөвшөөрсүгэй. Тус зээл нь Худалдаа хөгжлийн банкны эх үүсвэрт шилжих тохиолдолд жилийн 17,2% хүйтэй зээлэхийг зөвшөөрсүгэй.
- Зээлийн барьцаанд Монос Хүнс ХК-ийн
 - БГД 20-р хороо Үйлдвэрийн баруун бүс Сонсголонгийн Зам гудамж 32/3 тоот хаягтай 800 м.кв талбайтай Y-2205054309 дугаартай үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө,
 - БГД 20-р хороо Үйлдвэрийн баруун бүс /16103/ Сонсголонгийн Зам гудамж 32/6 тоот хаягтай 628.78 м.кв талбайтай Y-2205075822 дугаартай агуулахын зориулалттай үл хөдлөх хөрөнгө,
 - ХУД 3-р хороо Чингисийн өргөн чөлөө, 205/2 тоот хаягтай 1080 м.кв талбайтай Y-2206001751 дугаартай үйлдвэрлэлийн зориулалттай хоёр давхар үл хөдлөх хөрөнгө
 - ХУД 2-р хороо Чингисийн өргөн чөлөө 205/2 тоот хаягтай Э-2206000595 дугаартай 2198 м.кв хэмжээтэй үйлдвэрлэлийн зориулалттай газар эзэмших эрх
 - Ирээдүйд дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө,
 - Бараа, бэлэн бүтээгдэхүүн, түүхий эд, материалын үлдэгдэл,
- Зээлийн санхүүжилт авахаар банканд хүсэлт гаргах, зээл авахад шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлэн хүргүүлэх, банктай Зээлийн гэрээ болон барьцааны гэрээ байгуулах, гэрээнд компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /А.Отгондарь/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

Х.АНАНД

Л.ХҮРЭЛБААТАР

Ч.БАТТОГОХ

Б.ГАНТУЛГА

ОЛХАГВАСҮРЭН

Х.СОЛОНГО

Ц.ЦЭЦЭГБАДАМ



“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 10-ны өдөр


№ 04/05

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.1.18 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.10 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хавсралт 2, Компанийн дурмийн 7-р зүйлийн 7.1 заалтыг үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг энэхүү тогтоолын хавсралт №01-ээр батлан мөрдүүлсүгэй.
2. Энэхүү хөтөлбөрийг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн, биелэлтийг ханган, хууль тогтоомжид заасан хугацаанд нээлттэйгээр тайлagnаж ажиллахыг ТУЗ-ийн нийт гишүүд, Гүйцэтгэх захирал /А.Отгондарь/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Н.Цагаанхүү/ нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Х.АНАНД
ТУЗ-ИЙН ГИШҮҮД

Л.ХҮРЭЛБААТАР

Ч.БАТТОГОХ

Б.ГАНТУЛГА

О.ЛХАГВАСҮРЭН

Х.СОЛОНГО

Ц.ЦЭЦЭГБАДАМ
А.ОТГОНДАРЬ

2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн
хурлын 04/05 тогтоолын Хавсралт № 01



МОНОС ХҮНС ХК-ИЙН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр” гэх-/ийн зорилго нь Монос хүнс ХК-ийн засаглалын бодлогын баримт бичиг, дүрэм журмыг “Компанийн засаглалын кодекс”-ын зарчимд нийцүүлэн баталгаажуулж, үйл ажиллагаандaa нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангахад оршино.
- 1.2. Энэхүү хөтөлбөрийг компанийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/, гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнууд болон бусад оролцогчид дагаж мөрдөнө.

Хоёр. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

- 2.1. **Хөтөлбөрийн зорилт:**
 - 2.1.1. Хувьцаа эзэмшигчдийн эрхийг баталгаажуулах
 - 2.1.2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх
 - 2.1.3. Тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах
 - 2.1.4. Эрсдэлийн удирдлагыг сайжруулах
 - 2.1.5. Хяналтын тогтолцоог сайжруулах
- 2.2. **Хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:**
 - 2.2.1. Компанийн тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “Компанийн засаглалын кодекс”-т тусгагдсан бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг компанийн засаглалын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн боловсруулан батлах, мөрдүүлэх,
 - 2.2.2. Компанийн бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтэнд комплайнсын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх,
 - 2.2.3. Эрх бүхий албан тушаалтнуудыг компанийн засаглалын сургалтанд хамруулах,
 - 2.2.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлagnах, мэдээлэх,
- 2.3. **Хөтөлбөрийн зохион байгуулалт:**
 - 2.3.1. Энэхүү хөтөлбөрийг ТУЗ нь компанийн бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтанд нийцүүлэн баталж, холбогдох бодлогын баримт бичиг, дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавина.
 - 2.3.2. ТУЗ нь дараах чиглэлээр дүрэм, бодлогын болон бусад баримт бичиг баталж мөрдөнө.
 - 2.3.2.1. Ёс зүй
 - 2.3.2.2. Залгамж халаа
 - 2.3.2.3. Цалин, урамшуулал
 - 2.3.2.4. Ногдол ашиг
 - 2.3.2.5. Эрсдэлийн удирдлага

- 2.3.2.6. Дотоод аудит
- 2.3.2.7. Дотоод хяналт
- 2.3.2.8. Комплайнсын хяналт
- 2.3.2.9. Холбогдох хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, дотооддоо мөрдөх стандарт
- 2.3.3. ТУЗ нь дараах дотоод журмыг баталж мөрдөнө.
 - 2.3.3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын журам
 - 2.3.3.2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
 - 2.3.3.3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журам
 - 2.3.3.4. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
 - 2.3.3.5. Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам
 - 2.3.3.6. Дотоод хяналт, комплайнс, дотоод аудиторын үйл ажиллагааны бусад шаардлагатай журам

Гурав. ТАЙЛАГНАЛ, ҮНЭЛГЭЭ

- 3.1. **Үнэлгээ:** ТУЗ-өөс дараах үнэлгээ тайланг жил бүрийн эцэст хийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулан зохих байгууллагад хүргүүлнэ.
 - 3.1.1. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан үнэлгээний аргачлалын дагуу үнэлсэн тайлан
 - 3.1.2. Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан
- 3.2. **Тайлагнал:**
 - 3.2.1. ТУЗ нь засаглалын тайлан болон хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, явцын талаар жилийн үйл ажиллагааны тайланда тусган, Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсанд байршуулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.
 - 3.2.2. ТУЗ нь энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалын хамт Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.